



## **ДАМДИНГИЙН ЧИМЭДДАВАА**

Улаанбаатар хотын захиргааны дарга  
1933-1936 он

Богд хан аймаг, Дэлгэрхангай уул хошуу, одоогийн Дундговь аймгийн Эрдэнэдалай сум 1905 онд малчны гэр бүлд төрсөн.

1924 онд Цэргийн албанд мордож, анги салбаруудад байлдагчаас ахлах тушаалын дарга хүртэл алба хашжээ. Дараа нь БНМАУ-аас ЗСБНХУ-д суугаа Элчин сайд яаманд нарийн бичгийн даргаар ажилласан.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1933 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн 22 дугаар тогтоолын гуравдугаар зүйлээр Улаанбаатар хотын даргаар томилогдон гурван жил ажиллаад, 1936 оны долоодугаар сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дугаар тогтоолоор Хотын захиргааны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хотын захиргааны даргын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөний дараа Эд хэрэглэгчдийн хоршооны төв бараа бааз, Тээхийн ерөнхий хороо зэрэг газар алба хашжээ.

Тэрбээр Хотын захиргааны дарга байхдаа БНМАУ- долоодугаар их

хуралд Улаанбаатар хотоос төлөөлөгчөөр оролцож, Улсын бага хурлын гишүүнээр сонгогдож байсан.